



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/234

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн удирдлагууд төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг сонсох уулзалт зохион байгуулахад 3,467,900 (гурван сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн бусад арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.НОГСОМЖАВ

231010073

Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ... өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Томилолт	11хүн 4 хоног	26,500*44	1,166,000
2	Шатахуун- АИ-92	950/2 машин *330л/	2,520	957,600
3	Шатахуун /Дизель /	95 /1 машин *190л/	3380	642,200
4	Ахмад настан болон ахмад малчдад хүндэтгэл үзүүлэх			702,100
Дүн				3,467,900